

## “譯” хэмээх үсгийн гарлын асуудалд

Ш.Эгшиг /МУИС, ГХСС/

**Түлхүүр үг:** хэлмэрч түшмэл, орчуулга, Ёслолт ном, Хань улсын түүх, ху хэл, шаньюй

Хятад хэлний 译 (ум) хэмээх энэ ханз үсгийн утга бол орчин цагийн хятад хэлний үгийн тольд “орчуулга, орчуулах” гэсэн утгатай гэжээ. Энэ үгийн анхаарал татсан шалтгаан бол хятадын эртний сонгодог зохиолуудын нэг болох “Ёслолт ном”-ын “Вангийн ёс”-ны бөлөгт буй нэгэн хэсэгтэй холбоотой. Тэнд 《禮記 王制》: “五方之民, 言語不通, 嗜欲不同。達其志, 通其欲, 東方曰寄, 南方曰象, 西方曰狄鞮, 北方曰譯。 буюу “таван зүгийн ардын хэл нэвтрэлцэхгүй, дур өөр болой. Зоригт нь хүрч, дурд нь нэвтрэе хэмээгч нь дорно зүгт ‘жи’, өмнө этгээдэд ‘сян’, өрнө зүгт ‘ди ди’, хойд зүгт ‘и’ хэмээгдэх түшмэд бөлгөө.” гэсэн байдаг. Энд өгүүлэн буй хойд зүгийнхэнтэй хэл ул нэвтрэх тэрхүү түшмэд нь ‘и’ буюу хятадаар 譯 (ум) гэсэн үг юм. “Ёслолт ном”-ын доторхи энэ үгийг одоогийн бидний ухаарлаар төв оронд оршин байх хятад угсаатан түүний дөрвөн талд орших харь хэлтнийг нийлүүлээд таван зүг хэмээжээ. Тэд бүгдээр бие биеэсээ ялгаатай өөр өөр хэлтэй тул хоорондоо ойлголцон нэвтрэхэд бэрх хийгээд басхүү зан заншил, дур сонирхол бүгд өөр ажээ. Чингэхдээ “Ёслолт ном” бичигдэх тэр үед тэдгээр харь хэлтнүүдтэй хэл залгах одоогийн бидний хэлмэрч хэмээх бага зэрэгтэй түшмэд байсан бөгөөд дөрвөн зүгийнхээ гадаад улс тус бүрт нь өөр нэртэй хэл нэвтрэх түшмэд байжээ. Тухайлбал, зүүн зүгийн улстай харьцах түшмэлийг ‘жи’, өмнө зүгийн улстай хэл нэвтрэх түшмэлийг ‘сян’, баруун зүгийнхэнтэй хэл нэвтрэх түшмэлийг ‘ди ди’, хойд зүгийнхэнтэй нэвтрэх түшмэлийг ‘и’ гэж нэрлэж байжээ. “Ёслолт ном” бол Кунзын шавь нар хийгээд Байлдаант улс (МЭӨ 475-221-р он )-ын үеийн кунзын сурталтнуудын бүтээсэн сонгодог бүтээл юм. Энэ бүтээл уг нь анх 130 бөлөгтэй байсан нь Хятадын Тан улсыг хүртэл хялбарчлагдан засагдсаар эдүгээ 46 бөлөгтэйгээр уламжлан ирсэн ба үүний дотор “Вангийн ёс” хэмээх нэг бөлөг бий.

Тэгэхээр МЭӨ 4-3-р зууны үед 譯 (ум) хэмээх энэ ханз нь орчуулагч хэлмэрч хийх үндсэн ажилтай түшмэлийн нэрийдэл байжээ. Хятадын Хань улсын түүхэнд (《漢書》) МЭӨ 1-р онд болсон нэгэн үйл явдлын талаархи тэмдэглэлд 哀帝元寿二年 (公元前一年), “匈奴单于来朝, 宴见, 群臣在前”。哀帝的宠臣董贤也参加了宴会。“单于怪 (董) 贤年少, 以口译。上令译报曰: ‘大司马年少, 以大贤居位。’单于乃起拜, 贺汉得贤臣。” буюу “Хань улсын Айди хааны 2-р онд Хүннүгийн Шаньюй Хятадад ирэн хааны зоогон дээр олон түшмэдийн өөдөөс харан суужээ. Айди хааны энхрий түшмэл

(хайртай түшмэл) Дун Шиэн мөн оролцжээ. Хүннүгийн Шаньюй өмнөө буй түшмэлийг насаар тун залуу болохоор нь хэлмэрчээр дамжуулан Хань улсын хаанаас асуухад, Айди хаан мөн хэлмэрчээр дамжуулан, ‘Их түшмэл (цэргийн түшмэл) насаар бага ч их мэргэн хийгээд чадварт нэгэн тул түшмэлийн сууринд таарсан бөлгөө.’ хэмээхэд, Шаньюй суудлаасаа босон Хань улсын мэргэн түшмэлд баяр хүргэн ёсолсон гэжээ.”

Хань улсын түүхэнд тэмдэглэсэн өөр нэгэн баримтад мөн хэлмэрчийн тухай мэдээ байна. “中书谒者令宣持单于使者语，视诸将军、中朝二千石。Хань улсын төрийн ёслолын Шуан гэгч түшмэл Хүннүгийн элчийн хэлсэн үгийг хэлмэрчлэн, бичигт буулган тэмдэглэсэнээ олон жанжин хийгээд төрийн олон түшмэлийн (2000 түшмэл) өмнө уншиж дуулгажээ. Тэр бичигт “冒顿单于得汉美食好物，谓之恶，单于不来明甚。” “Хүннүгийн хаан Модун шаньюй Хань улсаас бэлэглэж илгээсэн амтат идээг үзээд, эвгүй муухай өмхий юм байна хэмээжээ. Үүнээс ухан үзвэл, Модун шаньюй энд (Хань улсад) ирэхгүй гэсэн хэрэг буй заа” гэжээ.

Хань улсын албан түүхэнд тэмдэглэсэн энэ хоёр баримтад 譯 (ум) гэсэн үг ‘хэлмэрчлэх орчуулах’ утгаар тэмдэглэгдсэн байна. Чингэхдээ эхний баримтад □ 譯 буюу ‘хэлмэрчлэх’ гэсэн утгаар байх ба дараагийн жишээнд мөн адил элчийн хэлснийг хэлмэрчлээд, түүнийг нь бичиж буулгасан гэсэн байгаагаас үзэхэд Хань улсын үед энэхүү ханзны утга нь голдуу ‘хэлмэрчлэх’ гэсэн утга илэрхийлж байсан бололтой байна. Тэгэхээр энэ үеэс даруй хоёр гурван зуун жилийн өмнө энэ үг хойд зүгийн харь хэлтний хэл яриаг залгуулах түшмэлийн нэрийдэл байснаа Хань улсын үе болж ирэхэд ‘хэлмэрчлэх’ гэсэн үйл үгийн утгаар хэрэглэгдэх болсон байна. “Ёслолт ном” бичигдэх үед энэхүү хойд зүгийн улстай хэл ул нэвтрэх ‘и’ нэрт түшмэлээс гадна зүүн зүгийн улстай харьцах түшмэлийг ‘жи’, өмнө зүгийн улстай хэл нэвтрэх түшмэлийг ‘сян’, баруун зүгийнхэнтэй хэл нэвтрэх түшмэлийг ‘ди ди’ гэсэн түшмэлүүд мөн ижил тэгш эрхтэйгээр хаан төрийн хэрэгт алба залгуулдаг байсан атал тэдгээр нь орчуулах хэлмэрчлэх гэсэн утгыг гаргахгүй байгааг орчин цагийн хятад хэлний толиос нягтлан үзэхэд хангалттай юм. Үүнээс ургуулан бодвоос, Хятадын түүхэнд Баруун, Зүүн Хань улсын оршин тогтноход хойд зүгийн нүүдэлчдийн нөлөө их байснаас тэдэнтэй харьцах давуу хэрэгцээ шаардлагын улмаас 譯 (ум) гэдэг ханзны хэрэглээ их байгаад энэ нь аажимдаа анхны утгаасаа шилжин ‘хөрвүүлэх, орчуулах’ гэсэн утгаар нь хэрэглэх болжээ. Энэ талаар хятадын судлаачид мөн дурдсан зүйл бий.

Хятадын түүхэнд Хань улсаас өмнө оршин тогтнож байсан Жоу (МЭӨ 1046-МЭӨ256) улсын үед улсын ёслолын алба хариуцсан түшмэлийг (象胥) сянсю гэдэг байсан ажээ. Сянсю нь дөрвөн зүгийн харь улсаас ирэх элч зочдыг угтан авдаг хэлмэрч түшмэл байсан юм. Энэ үгийг Жоу улсын үед л түгээмэл хэрэглэж байгаад, хожим хэрэглээ нь саарч, 譯 хэмээх түшмэлийн нэрэнд сууриа тавьж өгсөн шиг байна.

Зүүн Хань улсын Сю Шень хэмээгчийн зохиосон “Үсгийн тайлбар”<sup>71</sup>-т ‘译 үсэг бол дөрвөн зүгийн харийнхны хэлийг дамжуулагч бөлгөө’ (据东汉人许慎《说文解字》: “译”是传四夷之语者。) гэсэн байдаг. Энэ бол Хань улсын үед энэхүү үгийг тайлбарласан нь юм. Мөн Хань улсын түүхэнд ‘Холоос элч ирвээс, есөн зүйлийн аргаар орчуулган хэл нэвтрэх бөлгөө’ (“远国使来, 因九译言语乃通也。”) гэсэн байдаг. ‘Есөн зүйлийн арга’ хэрэглэн гэсэн нь орчуулан хэлмэрчилж болох бүхий л аргыг хэрэглэх гэсэн санаа бөгөөд үүнд хэрэв шууд хэлмэрчлэх хятад хүн эс олдох аваас өөр хэлээр дамжуулан ойлголцох, эсвэл тэрхүү холын улстай хил зэрэгцэн орших ардын дундаас хятад хэл мэддэг хүнийг олж орчуулгах, эсвэл ойр дөрвөн зүгийн хил залгаа орны иргэдээс хэлмэрчлүүлэх зэрэг аль бүхий аргаа хэрэглэнэ гэсэн үг юм.

譯 (ум) хэмээх ханзны утгыг хятад хэлний толь бичгүүдээс шүүж үзвэл дараахь мэт байна.

1. Манжийн Энх-Амгалан хааны зохиолгосон үсгийн толь<sup>72</sup>-д (康熙字典 Энх-Амгалан хааны зарлигаар 1710 онд эхэлж, 30 гаруй эрдэмтдийн хүчээр 1716 онд хийж дууссан нийт 47035 ханз үсэгтэй толь бичиг) “傳譯四夷之言者” буюу “дөрвөн зүгийн харийнхны үгийг дамжуулан орчуулагч” гэсэн нь дээр өгүүлсэн Зүүн Хань улсын Сюшений тайлсантай бараг адил тайлбар байна.
2. Хятад хэлний үгийн гарлын толь “辞源<sup>73</sup>”-д 1. 傳譯四夷之言者。見<說文>。謂傳他國之語言文字而達其意也。2. 詁釋經義亦曰譯。<潛夫論考績> 賢人為聖譯。 гэсэн нь нэгдүгээр утга нь Энх-Амгалангийн үсгийн тольд байгаатай утга ижил, хоёрдугаар утга нь судрын утгыг тайлбарлахыг мөн орчуулан хөрвүүлэх гэнэ гэжээ.
3. Хятад хэлний их толь бичиг “中文大辭典<sup>74</sup>”-д хятад хэлний үгийн гарлын тольд буй хоёр утга байгаагийн дээр гурав, дөрөвдүгээр утга нь хятадын нутгийн аялгууны утга болох харах, үзэх ба шилэн сонгох гэсэн утгыг тэмдэглэн оруулжээ.
4. Хятад үгийн далай хэмээх “辭海<sup>75</sup>”-д нэгдүгээр утга нь ‘нэг хэлний үгийг нөгөө хэлний үгээр орчуулан хөрвүүлэхийг хэлнэ. Эрт цагт судрын утгыг тайлбарлахыг мөн хэлдэг байжээ.’ Хоёрдугаар утга нь ‘эрт цагт хойд зүгийн үндэстний хэлийг орчуулагч түшмэлийг нэрлэдэг.’ гэсэн байна.

Хятадын сүүлийн үеийн эрдэмтэн ба дипломатч нарын бичсэн өгүүллүүдэд энэхүү 譯 (ум) үсгийн үүслийн талаар дурдсан зүйл нэлээд их гарчээ. Тухайлбал, БНХАУ байгуулагдсан үеэс ажиллаж байсан зөвлөх дипломат Ма Баофен чөлөөнд

<sup>71</sup>許慎撰，徐鉉校定：《說文解字附檢字》，北京：中華書局，2004年

<sup>72</sup>康熙字典 同文书局原版，光緒十三年丁亥（1887）孟夏印，頁1188第18字

<sup>73</sup>辞源，商务印书馆香港分店，1986，743页

<sup>74</sup>中文大辭典，中國文化大學印行，1990年，第八冊，1150頁，第36856字

<sup>75</sup>辭海，1989年版，上海辭書出版社，第443頁

гарснаас хойш Хятадын шинэ үеийн гадаад харилцаанд холбогдох олон түүхэн баримтат өгүүлэл бичсэн юм. Тэрээр “Эртний орчуулгын ажлыг тандах нь”<sup>76</sup> өгүүлэлдээ хятадын эрт цагийн хойд зүгийн орчуулгын түшмэлийн нэрийдэл Хятадын Хань улсын үеэс одоогийн ‘орчуулагч, орчуулах’ гэдэг утгандаа бүрэн шилжсэн байна гэсэн юм. Хятадын Ниньбогийн их сургуулийн Хө Айжүнь, Чяо Лулу нарын бичсэн “译 -ээс 翻译-д хүртэл”<sup>77</sup> гэдэг өгүүлэлд 譯 (ум) үсгийн үүсэл нь дээр өгүүлсэнтэй адил хийгээд харин эдүгээ хэрэглэж буй хоёр үет 翻譯 (орчин үеийн ‘орчуулах’ гэдэг үг) хэмээх үг болсон нь шашны ном зохиолыг орчуулах үед хамаарч байна. Зүүн Хань улсын үед шашны ном судар орчуулж эхэлсэн бөгөөд Тан улсын үед оргилдоо хүрч, Сүн улсын үеэс хятад хэлээр шашны зохиолыг барлаж эхэлсэн гэдэг. Анхлан 譯 (ум) нь хойд зүгийн нүүдэлчидтэй харилцах нь ихсэж, тэдний соёлоос нэвтэрч, танин мэдэх шаардлагын улмаас хэлмэрчлэх, орчуулах ажил нь энэ зүгт илүү төвлөрсөнтэй холбогдон бусад зүгийнхэнтэй харилцах харилцаа нь саарсан зэргээс шалтгаалан зөвхөн энэ үгээр л хэлмэрчлэх, орчуулах түшмэлийн нэрийн хэрэглээ ихэссэнээс бусад ‘жи, сян, диди’ гэсэн үгсийг аажмаар хэрэглэхээ больж, мөнөөх ‘и’ хэмээх үгэнд байраа тавьж өгсөн хэрэг. 譯 (ум) нь яваандаа түшмэлийн нэрнээс ‘хэлмэрчлэх’ гэсэн үйл үг болж, тэр нь бас улмаар бичгийн орчуулгыг бас хамаарах болж, цаашлаад бурхны шашин Хятадад дэлгэрснээр шашны ном зохиол орчуулах шаардлагын үүднээс ху хэл<sup>78</sup> ба самгард хэлнээс хятад хэл рүү орчуулах гэсэн утгыг агуулах болсон байна. Энэ үед шашны зохиол орчуулахад урьдын ‘хэлмэрчлэх, орчуулах’ утгаас гадна шашны судар орчуулах нөр их ажлын явцад орчуулах үйлийг дан ганц 譯 (ум) гэдэг үсгээр илэрхийлэх нь хангалтгүй болж, 翻 (fān) хэмээх үйл үгийг давхар хэрэглэж эхэлжээ. Гэхдээ энэ үгийг баттай хэрэглэж заншсан үе нь бүр Тан улсын үед гарсан бичгийн дурсгалаас үзэгддэг байна. Тэгэхээр эндээс гарах нэг гаргалгаа бол монголчуудын өвөг дээдэс бурхны шашны зохиолыг хэдийн өөрийн хэлээр орчуулсан байсан эсвэл бүр туурвисан байсныг хятадын Хань улсын үеэс хятад хэл рүү орчуулж байсан болж таарч байгаа юм.

Эцэст нь дүгнэхэд, монголчууд бид хятадын хэлмэрчлэхүй, орчуулгын түүхэнд тун гүнзгий мөрөө гаргасан ард түмэн ажээ. Хятадын сонгодог зохиол болох “Ёслолт номд” бүхий хятадтай харьцаж байсан дөрвөн зүгийн үндэстэн тус бүртэй хэлмэрчлэх үүрэгтэй түшмэлийн нэрийдлээс эдүгээ зөвхөн хойд зүгийн нүүдэлчдийн хэлээс

<sup>76</sup> 马保奉, 古代翻译工作浅探 发布日期: 2010-05-14, 山东省外事信息网

[http://www.sdfo.gov.cn/art/2010/5/14/art\\_550\\_1908.html](http://www.sdfo.gov.cn/art/2010/5/14/art_550_1908.html)

<sup>77</sup> 贺爱军, 乔璐璐 “从‘译’到‘翻译’” 宁波大学学报(人文科学版), 第26卷, 第一期, 2013年1月第42页

<sup>78</sup> Ху хэл нь одоогийн шинжаан, монголын нутагт аж төрж байсан эртний омог үндэстний нийтлэг хэл бөгөөд тухайн үед энэ хэлт ард түмнүүдтэй харилцах нь хань үндэстний гадаад харилцааны түүхэнд чухал суурь эзэлж байсан юм.

хэлмэрчилдэг түшмэлийн нэр нь хэлний түүхэн олон үе шат, шалгуурыг давсаар эдүгээ ‘орчуулах’ гэсэн утга бүхий үгийн аймгийн өөр ай болох үйл үг болж хятад хэлний хамгийн түгээмэл хэрэглэгдэх үг болсон байна.

Номзүй:

1. 葉衡 選註, 《禮記》, 學生國學叢書, 台北市, 台灣商務印書館, 1964. 12.
2. 漢書, 班固著, 中華書局, 顏師古註釋, 全十二冊, 1962. 6.
3. 許慎撰, 徐鉉校定: 《說文解字附檢字》, 北京: 中華書局, 2004 年
4. 康熙字典 同文书局原版, 光緒十三年丁亥 (1887) 孟夏印
5. 辭源, 商務印書館香港分店, 1986年
6. 中文大辭典, 中國文化大學印行, 1990年
7. 辭海, 1989年版, 上海辭書出版社
8. 馬保奉, 古代翻譯工作淺探 发布日期: 2010.05.14, 山东省外事信息网

[http://www.sdfao.gov.cn/art/2010/5/14/art\\_550\\_1908.html](http://www.sdfao.gov.cn/art/2010/5/14/art_550_1908.html)

9. 賀愛軍, 喬璐璐 “从‘译’到‘翻译’” 宁波大学学报(人文科学版), 第26卷, 第一期, 2013年1月

### Summary

In this paper the author focused on origin of chinese character 譯 (ym). Meaning of this character is ‘translate’ and this word was used as official person who responsible for interpreting from north tribes language (Mongolian ancestors’ language).